



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/998

Мандалговь

Бүтэц, орон тоо шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17, Төсвийн тухай хуулийн 14.2.12, 65 дугаар зүйлийн 65.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудитаар өгсөн зөвлөмж, Аймгийн Засаг даргын 2021 оны А/178 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу Боловсролын газрын бүтэц, орон тоог нэгдүгээр хавсралтаар, Биеийн тамир спортын газрын бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын бүтэц орон тоог гуравдугаар хавсралтаар, Мал эмнэлгийн газрын бүтэц орон тоог дөрөвдүгээр хавсралтаар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын бүтэц орон тоог тавдугаар хавсралтаар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын бүтэц орон тоог зургаа дугаар хавсралтаар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтэц орон тоог долоо дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын албан хаагчдын цалинг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолыг үндэслэн цалингийн санд багтаан олгохыг нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн Засаг даргын 2019 оны 2019 оны А/381, А/382, 2020 оны А/37 дугаар захирамжуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



481210885